



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар 1390

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 4-ний өдрийн 64 дүгээр зөвлөмжийн дагуу Баянтээг ХК-ийн нүүрсийг коксжуулж, био холбогчтой бүрэн шаталттай шахмал түлш үйлдвэрлэх үйлдвэрийг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр байгуулах, тус үйлдвэрт тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын 1 дүгээр багцыг 799500000 (долоон зуун ерэн есөн сая таван зуун мянга), 2 дугаар багцыг 397280000 (гурван зуун ерэн долоон сая хоёр зуун наян мянга) төгрөгөөр Баялаг-Эрдэнэ цом ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Баянтээг ХК (О.Сумъяасүрэн)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Баянтээг ХК-ий нягтлан бодогч (Ю.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100640